



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар A/10

Мандалговь

“Өндөршил сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”
зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өндөршил сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)
---------------------------	---

Гишүүд:	Н.Мэндсайхан (Иргэний төлөөлөл) Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
---------	---

Нарийн бичиг:	Г.Оюунтунгалаг (Аймгийн засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан) М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
---------------	--

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  И.Доржбат

4822150011